БАТЛАВ. БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН ДАРГА /А.ЭНХБАТ/

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

"БАС ГОВЬ ГРУПП" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /М.ОТГОНБАЯР/

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН 1-Р БАГИЙН НУТАГТ ХЭРЭГЖИХ "АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ЛОЖИСТИК ТӨВ" ТӨСЛИЙН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР: /4279344/

ХЯНАСАН:

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН /П.ШИНЭЦЭЦЭГ/

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

"БАС ГОВЬ ГРУПП" ХХК-ИЙН МЕНЕЖЕР /У.БАТЖАРГАЛ/

2022 ОН

**Агуулга**

1. Тухайн жилийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн товч танилцуулга

2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

9. Дүгнэлт

10. Тайлангийн хавсралтууд

# ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

"Ачилт буулгалтын ложистик төв" төсөл нь Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутаг дэвсгэрт байрлах 10.3 га талбайд 2021 оны 05 дугаар сараас эхлэн үйл ажиллагаа явуулж байна.

Энэхүү төслийн үйл ажиллагаа нь нэг цэгээс нөгөө цэг рүү өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, барилга, уул уурхайн салбарын том оврын тоног төхөөрөмж болон манай улсын нутгаар дайран өнгөрөх транзит ачааг шилжүүлэн ачиж тээвэрлэх, төмөр замын тээвэрлэлттэй холбоотой гаалийн бүрдүүлэлт хийх, терминал өргөлт буулгалт, хаалганд хүргэх болон дотоод түгээлтийн үйлчилгээнүүдийг давхар хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн. Энэ хүрээнд 2 салаа терминалтай, 50 вагон хүлээн авах хүчин чадалтай төмөр зам барихаар төлөвлөсөн.

Ачаа буулгах талбай нь 700 ширхэг контейнер хадгалах хүчин чадалтай. Одоогийн байдлаар нийт талбайн 51.45 хувьд нь буюу 5.3 га талбайд түүхий нүүрс буулган түр хадгалах үйл ажиллагаа явуулж байна.

Цаашид бүх төрлийн ачаа буулгах өндөрлөсөн тавцан, задгай вагоноос хүнд даацын машин техник шууд хөлөөр нь буулгах тавцан, 50 тн-ын даацтай гүүрэн кран байрлуулах, гаалийн хяналтын бүс дотор задгай ачаа хадгалах зориулалт бүхий 3 ширхэг саравч, криты вагоноос шууд гаалийн баталгаат агуулах руу оруулах зориулалт бүхий 3 ширхэг агуулах, оффисын барилга, ачаатай вагоны жинг үзэх зориулалттай вагон пүү, ачаатай автомашиныг жинлэж оруулаад гарахад нь хоосноор жинлэж талбайд буусан ачааны жинг гаргах зориулалттай электрон авто пүү, 4500 м2 талбайтай бүх төрлийн энгийн болон гаалийн баталгаат дулаан агуулах, ачаа болон чингэлэг тээвэрлэх 4 ширхэг сэрээт ачигч, машин техникүүд бүхий барилга байгууламжуудыг үе шаттайгаар барьж байгуулахаар төлөвлөсөн.

2022 онд байгаль орчны мэргэжлийн байгууллага болох "Нью грийн ворлд" ХХК-иар "Ачилт буулгалтын ложистик төв" төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгүүлж тайланг БОАЖЯ-аар 2022 оны 02 сарын 09-ний өдөр батлуулсан.

2020 оноос Дэлхий нийтэд "КОВИД-19" цар тахал гарсантай холбоотойгоор манай компаний цахилгаанд холбогдох ажил зогсонги байдалтай байсан. 2022 оны 4-р сарын 20-ноос 5-р сарын 20-ны дотор нэг сарын хугацаатай "Женерал энерго строй" ХХК-тай цахилгаанд холбуулах гэрээ байгуулсан боловч тус хугацаанд гүйцэтгэгч компани болох "Женерал энерго строй" ХХК-ийн ажил удааширсантай холбоотойгоор манай компаний төлөвлөгөөт ажил хойшилж 2022 оны 11-р сарын 07 өдөр цахилгаанд холбогдсон.

Энэ хугацаанд барилгын материалын үнэ өдрөөс өдөрт өсөж байгаа бөгөөд мөн хүйтний улирал эхэлж газар хөлдсөн тул оффисын барилга болон бусад бүтээн байгуулалт, тохижилтын ажлыг 2023 оноос үе шаттайгаар хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.

## 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| Д/д | Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Тоо хэмжээ | Нийт зардал | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| Цаг уур, уур амьсгал | | | | | | |
| 1. | Цаг уурын гэнэтийн, аюултай үзэгдлийн улмаас болзошгүй осол аваар гарах | Хүчтэй аадар бороо орох, хүчтэй салхилах, цасан болон шороон шуурга шуурах зэрэг байгаль цаг уурын аюултай үзэгдлийн үед барилга, газар шорооны ажил болон материал тээвэрлэлт, ачилт буулгалтын үйл ажиллагаар түр зогсоох, техник хэрэгслүүдийг унтрааж, ажиллагаар зогсоох | Төслийн хэрэгжилтийн бүх үе шатанд, шаардлагатай үед | - | - | Хүчтэй салхилах, цасан болон шороон шуурга шуурах зэрэг байгаль цаг уурын аюултай үзэгдлийн үед ажилчдыг төслийн талбай дээр ажиллуулахгүй байх, ачилт буулгалтын үйл ажиллагаар түр зогсоох арга хэмжээ авч ажилласан. |
| Агаарын чанар | | | | | | |
| 2 | Төслийн талбайн ихэнхи хэсэг нь эвдэрч сул шороон гадаргатай болсон тул агаарт тоосжилт үүсгэнэ. | Эдэлбэр газар дахь нүүрс болон бусад ачаа буулгах талбай, автомашины зогсоолыг хатуу хучилттай болгох | 2022 оны 9, 10-р сард | 600-1000 | 800000 | Төслийн талбайн гадна байрлах 100х90 хэмжээтэй газрыг 168м$^3$ буюу 201.6 тонн хайрга буулгаж авто машины зогсоолыг бий болгосон. |
| 3 | Сайтар угааж шигшээгүй, нарийн тоос ихтэй элс, хайргыг ашиглах, тээвэрлэх үед агаарт тоос үүснэ. | Барилгын ажилд стандартын дагуу сайтар угааж шигшсэн элс, хайрга, дайрга ашиглах | Барилгын үед | - | - | Төслийн талбайд цахилгаан татах ажил хойшилж хийгдсэн тул энэ онд барилгын ажлыг хийж гүйцэтгээгүй. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | Шороон замаас тоос үүсч агаар бохирдуулах | Сумын төвийн хатуу хучилттай авто замаас салаад төслийн талбай хүртэл шороон замаар зорчих ачаа тээврийн автомашинуудын хурдыг 30-40 км/цаг-аар хязгаарлах буюу энэ хурднаас хэтрүүлэхгүй байх зохицуулалт хийх | Тогтмол | - | - | Төслийн талбайд 2021 онд 89000 тонн нүүрс буулгасан бөгөөд 2022 онд шинээр нэмж нүүрс болон бусад бүтээгдэхүүний тээвэрлэлт, буулгалтын ажил хийгдээгүй болно. |
| 5 | Шороон замаас тоос үүсч агаар бохирдуулах | Төслийн талбай хүртэлх шороон зам дагууд замын анхааруулах тэмдэг тэмдэглэгээ, төслийн талбайн байршлыг заасан самбар байршуулж, тээврийн хэрэгслүүдийг зөвхөн нэг замаар зорчих нөхцөлийг бүрдүүлэх, шинээр олон салаа шороон зам үүсгэхгүй байх арга хэмжээ авах | 2022 оны 5 сард | - | - | 2022 онд тээвэрлэлт, буулгалтын ажил хийгдээгүй бөгөөд шинээр олон салаа шороон зам үүсгээгүй болно. |
| Газрын гадарга, хөрсөн бүрхэвч | | | | | | |
| 6 | Шаардлагагүй газарт газар хөндөх, ухаш овоолго үүсгэж газрын гадарга, хөрсөн бүрхэвчийг талхлан доройтуулах | Барилгажих талбайн гадна талаар хамгаалалтын зурвас байгуулж, хамгаалалтын зурвас доторх газарт төлөвлөлт, зураг төслийн дагуу үйл ажиллагаа явуулах | Барилгын ажил эхлэхийн өмнө 2022 оны 2, 3-р улиралд | - | - | Төслийн талбайд цахилгаан татах ажил хойшлогдож 11 сард хийгдсэн тул энэ онд барилгын ажлыг хийж гүйцэтгээгүй. |
| 7 | Газрын гадарга, хөрсөн бүрхэвчийн өнгөн хэсэг элэгдэх, ургамлан нөмрөг устах | Барилгын материалуудыг аль болох нэг цэгт төвлөрүүлэх | Барилгын ажлын үед | - | - | Төслийн талбайд цахилгаан татах ажил хойшлогдож 11 сард хийгдсэн тул энэ онд барилгын ажлыг хийж гүйцэтгээгүй. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8 | Хөрсөн бүрхэвч хүний хөлөөр талхлагдан доройтох | Төслийн талбайд 2 хүн зэрэг зөрж болохуйц 1.5-2.0 метр өргөнтэй явган хүний замыг байгалийн чулуугаар хийж, явган хүний замаас гадуур алхахгүй байхыг нийт ажилчдад анхааруулах | 2022 оны 2,3-р улиралд | - | - | Төслийн талбайд оффиссын барилга баригдсаны дараа явган хүний замыг хийхээр төлөвлөсөн. Цахилгааны асуудлаас болж оффисын барилгын ажил хийгдээгүй. |
| Газрын доорх ус | | | | | | |
| 9 | Зөвшөөрөлгүй гүний худаг гаргаж усны тухай хууль зөрчиж болзошгүй. | Усны тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу эхлээд аймгийн Байгаль орчны газраас гүний худаг гаргах зөвшөөрөл авах, зөвшөөрөлд үндэслэн худаг гаргах | 2022 оны 2, 3-р улиралд | - | - | 2021 онд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас Цооног өрөмдөх зөвшөөрөл авч "Топ дриллинг" ХХК-иар шинээр худаг гаргасан. |
| 10 | Баримт бичгийн зөрчил үүсгэх | Худгийн паспортыг холбогдох төрийн байгууллагаар баталгаажуулж, эх хувиар нь хаяж үрэгдүүлэхгүй хадгалах | Тогтмол | - | - | "Топ дриллинг" ХХК-иас худгийн техникийн паспорт бичүүлэн авч аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргаар баталгаажуулсан. |
| 11 | Газрын доорх ус бохирдож болзошгүй | Хатуу, шингэн хаягдлын цэгүүдийг гүний худгаас 200 метрээс гадагш зайтай байрлуулах, гүний худагт энгийн хамгаалалтын бүс тогтоох | Тогтмол | - | - | Нийтийн бие засах газрыг гүний худгаас хол зайтай байгуулсан. |
| 12 | Ус хэрэглээ хяналтгүй, зохисгүй зарцуулагдах | Гүний худагт баталгаажсан усны хяналтын тоолуур суурилуулж, усны хэрэглээг тогтмол хянах | 2022 оны 2, 3-р улиралд | - | - | Цооногийг ашиглаж эхлээгүй байна. Оффисын барилгын ажил 2023 оноос эхлэх бөгөөд шинээр гаргасан цооног дээр барилга барихаар төлөвлөсөн. |
| Ургамлан нөмрөг | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 13 | Барилгын ажлын нөлөөгөөр байгалийн ургамлан нөмрөг устах, доройтох | Барилгын материал, машин механизмуудыг ургамлан нөмрөг бага буюу аль болох халцгай эсвэл хатуу хучилттай газарт байрлуулах, байгалийн ургамалтай газарт барилгын материал буулгах, машин механизмын зогсоол болгон ашиглахгүй байх | Барилгын ажлын үед | - | - | Төслийн талбайд цахилгаан татах ажил хойшлогдож 11 сард хийгдсэн тул энэ онд барилгын ажлыг хийж гүйцэтгээгүй. |
| Амьтны аймаг | | | | | | |
| 14 | Төслийн талбай орчмын ЦДАШ дээр шувуу сууж тогонд цохиулах эрсдэлтэй | Төслийн талбай орчимд шувуу үргээгч суурилуулах | 2022 оны 2, 3-р улиралд | - | - | Төслийн талбайд шувуу үргээгч суурилуулах ажлыг 2023 онд хийж гүйцэтгэнэ. |
| 15 | Хууль бус ан агнуурын үйл ажиллагаа явагдах | Нийт ажилчдад хууль бус ан агнуур хийхгүй байх, худалдаалахгүй байх талаар анхааруулга өгч, хяналт тавьж ажиллах | Тогтмол | - | - | Ажилчдад хууль бус ан агнуур хийхгүй байх талаарх санамж өгсөн. |

## 2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

| Д/д | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Тоо хэмжээ | Нийт зардал | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Эдэлбэр газар дахь эвдэрч доройтсон газрыг зүлэгжүүлж, хөрс сайжруулах | Барилга, газар шорооны ажил дууссаны дараа эвдрэлд орсон талбайг хэлбэршүүлэх, тэгшлэх, үржил шимт хөрсөөр хучих, шаардлагатай тохиолдолд хөрс сайжруулалт хийх зэргээр ургамалжуулах урьдач нөхцөлийг | 2022 оны 05 сард | - | - | Төслийн талбайд оффисын барилга болон бусад шаардлагатай барилгын ажлыг гүйцэтгэсний дараа талбайн тохижилт, ногоон байгууламжийн ажлыг хийх боломжтой болно. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | бүрдүүлэх | | | | |
| 2 | | Тэгшилж зассан газарт нэг болон олон наст ургамлын /ерхөг, согоовор, хялгана, сонгино, таана/ үр тарих | 2022 оны 06 сард | - | - | Төслийн талбайд оффисын барилга болон бусад барилгын ажлыг гүйцэтгэсний дараа шаардлагатай газрыг зүлэгжүүлэх боломжтой болно. |
| 3 | Төслийн талбайгаас үүсэх тоосжилт, хийн хаягдлыг шингээх, хөрс хамгаалах, нөхөн сэргээх | Төслийн талбайг тойруулан нийт 200м урттай, 1400м$^2$ орчим талбайд мөр хоорондын зай 3.5м, эгнээ хоорондын зай 3м байхаар тооцон 2 эгнээ бүхий 115 ширхэг мод сөөг тарьж ойн зурвас байгуулах | 2022 оны 9, 10 сард | - | 1200000 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" хөдөлгөөний хүрээнд төслийн талбайд 400 ширхэг хайлаас модыг шинээр тарьсан. Тарьц суулгацыг Сум дундын ойн ангиас авч тарьсан. |
| 4 | Төслийн талбайгаас үүсэх тоосжилт, хийн хаягдлыг шингээх, хөрс хамгаалах, нөхөн сэргээх | Мод тарих ажлыг мэргэжлийн байгууллагын заавар зөвлөмжийн дагуу гүйцэтгэх ба орон нутгийн уур амьсгалд тохирсон улиас, хайлаас, бүйлс, гүйлс, голт бор, тавилгана зэрэг хээрийн бусад тарихад тохиромжтой мод сөөгийг тарьж, усалгаа, арчилгааг тогтмол хийх | 2022 оны 9, 10 сард | - | - | Мод тарихдаа Сум дундын ойн ангийн мэргэжилтнээс заавар зөвлөгөө авч тарилтыг хийсэн. Мөн тус байгууллагын 25 тонны усны машинаар усалгаа хийсэн. |
| 5 | Ногоон байгууламжийг хамгаалах | Ногоон байгууламжийн ургалт хэвийн болж тогтворжих хүртэл хамгаалж хашаалах | 2022 оны 9, 10 сард | - | - | Сум дундын ойн ангийн усны машинаар 2 удаа усалгаа хийсэн. |
| **ДҮН** | | | | | **1.200.000** | |

### 3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Төслийн талбай орчимд түүх, соёлын өв байхгүй бөгөөд барилга байгууламжийг барих, газар шорооны ажлын үед газрын хөрсөн доороос түүхийн дурсгалт зүйл, соёлын өв илэрсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-т заасны дагуу ажлаа зогсоож, энэ тухай сумын Засаг дарга болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэх болно.

## 4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

| Д/д | Хог хаягдлын төрөл болзошгүй сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Тоо хэмжээ | Нийт зардал | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ахуйн хатуу хаягдлаар орчныг бохирдуулах | Хатуу хаягдлыг эх үүсвэр дээр нь 4-5 төрөлд ангилан ялгах боломжтой, бетон эсвэл төмөр суурьтай, битүүмжлэл сайтай нэгдсэн түр цэг байгуулах | 2022 оны 1-р улиралд | - | 600000 | Ахуйн хатуу хог хаягдлыг агуулах зориулалттай 150x150см задгай cааралжин хогийн сав байршуулж "Тохижилт Сүмбэр" ОНӨҮГ-тай гэрээ байгуулан хогийг тогтмол ачуулж байна. |
| 2 | Ахуйн хатуу хаягдлаар орчныг бохирдуулах | Төслийн талбайн 2-3 цэгт хог ангилан ялгах зориулалттай савнуудыг байршуулах, савнуудад ямар төрлийн хаягдал хийх тухай зааварчилгаа, тэмдэглэл наасан байх | 2022 оны 1-р улиралд | - | - | Оффиссын барилга баригдсаны дараа байгууллагын гадна ангилан ялгах хогийн сав байршуулахаар төлөвлөсөн. |
| 3 | Хатуу хаягдал | Нэг удаагийн ахуйн хэрэглээнээс татгалзах буюу нэг удаагийн аяга таваг болон бусад зүйлсийг огт хэрэглэхгүй байх, ахуйн хэрэглээний материалын аль болох олон удаа ашиглах байдлаар үүсэж болох хаягдлыг бууруулах | Тогтмол | - | - | Одоогоор компаний үйл ажиллагаа жигдрээгүй байгаа тул нийт 4 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна. Ажилчдын ахуйн хэрэглээнээс бага хэмжээний хог хаягдал гардаг бөгөөд нэг удаагийн ахуйн хэрэглээ хэрэглэдэгтүй. |
| 4 | Хатуу хаягдал | Ангилан ялгасан ахуйн хатуу хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх | Жилд 2 удаа | - | - | Төслийн үйл ажиллагаанаас дахивар буюу бага хэмжээний хуванцар гардаг бөгөөд тухайн хог хаягдлыг хуримтлуулж дахивар авах цэгт 1 удаа өгсөн. |
| 5 | Хатуу хаягдал | Дахин боловсруулах боломжгүй хаягдлыг хог хаягдлын төвлөрсөн цэг рүү тээвэрлэх | Сард 1 удаа | - | 400000 | Ахуйн хэрэглээнээс гарч буй хог хаягдлыг хог хаягдал хадгалах түр цэгт хуримтлуулж "Тохижилт Сүмбэр" ОНӨҮГ-аар ачуулж байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6 | Ахуйн шингэн хаягдлаар хөрсөн бүрхэвч, газрын доорх ус бохирдох | Хоногт 1.3$м^3$ шингэн хаягдлыг цэвэрлэх хүчин чадалтай бага оврын цэвэрлэх байгууламж байгуулан цэвэршүүлэх | 2022 оны 2, 3-р улиралд | - | - | Одоогоор стандартын шаардлага хангасан доторлогоотой нүхэн жорлон ашиглаж байгаа бөгөөд оффисын барилга баригдаж үйл ажиллагаа жигдэрсэн тохиолдолд бага оврын цэвэрлэх байгууламжийг бий болгож ашиглах нөхцөл бүрдэх боломжтой. |
| 7 | Ахуйн шингэн хаягдлаар хөрсөн бүрхэвч, газрын доорх ус бохирдох | Стандартын шаардлагад нийцсэн ажилчдын бие засах газар буюу ариун цэврийн байгууламж байгуулан цэвэрлэх байгууламжтай холбох | 2022 оны 2, 3-р улиралд | - | - | Төслийн гадна талбайд хоёр хүний суултууртай бохир соруулах зориулалттай 900 диаметрийн 2 давхар бетон кольцо болон тавцантай нийтийн бие засах газар шинээр хийж гүйцэтгэсэн. |
| 8 | Аюултай хаягдал | Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээнээс үүсэх сэлбэг хэрэгсэл, шатах тослох материалаар бохирдсон хаягдал, тосны шүүр, аккумлятор зэрэг аюултай хог хаягдлыг тусгай агуулахад түр хуримтлуулан аюултай хаягдал устгах болон дахин боловсруулах мэргэжлийн байгууллагад шилжүүлэх | Тогтмол | - | - | Техникийн тос тосолгооны материал, засвар үйлчилгээнээс үүссэн хогийг тусгай агуулахад түр хадгалдаг. |
| | **ДҮН** | | | | | |

## 5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

| д/д | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналт шинжилгээ хийх байршил | Тоо хэмжээ | Нийт зардал | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **1. Агаарын чанарын мониторинг** | | | | | |
| 1 | Хорт хий, бохирдуулагч, дуу чимээний | | Агаарын | 400000 | Говьсүмбэр аймгийн Ус цаг, уур |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | түвшин:<br>• Тоос /TSP, PM10, PM2.5/<br>• $CO_2$, $SO_2$, $NO_2$<br>• Дуу шуугиан | Оффисын барилгын орчим | найрлага жилд 1 удаа | | орчны шинжилгээний төвөөр агаарын шинжилгээ хийлгэсэн. |
| **2. Хөрсний чанарын мониторинг** | | | | | |
| 1 | Нянгийн бохирдол: /1 гр-д Колититр/<br>Хөрсний ерөнхий шинжилгээ<br>Хөрсөн дэх хүнд металлын агууламж | Хатуу, шингэн хаягдлын цэгүүд, бие засах газрын орчим | 1 дээж | 400000 | Говьсүмбэр аймгийн Ус цаг, уур орчны шинжилгээний төвөөр хөрсний шинжилгээ хийлгэсэн. Нийт төслийн талбайн 3 хэсэг бүхий талбайгаас хөрсний дээж авч шинжлүүлсэн. |
| | | Нөлөөлөлд өртөөгүй эрүүл талбай | | | |
| | | Машин механизмын зогсоолын талбай, нүүрс овоолгын талбай | | | |
| **3. Усны чанарын мониторинг** | | | | | |
| 1 | Усны химийн ерөнхий шинжилгээ | Гүний худгийн ус | Жилд 1 удаа | | Гүний худгийн усыг ашиглаж эхлээгүй байгаа тул шинжилгээнд хамруулаагүй болно. |
| 2. | Усан дахь бохирдуулагч бодисуудын хэмжээ тодорхойлох | | | | |
| | **ДҮН** | | | | |

**6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө**

| д/д | Төлөвлөж буй ажил | Нийт зардал | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | Үйл ажиллагаа явуулахтай холбогдуулан төрийн байгууллагын хяналт шалгалт, орон нутгийн Засаг захиргаанаанаас тавьж буй шаардлага зөвлөмжийг биелүүлж хамтран ажиллах. | 1500000 | Нийгмийн хариуцлагын хүрээнд дараах үйл ажиллагаанд идэвхитэй оролцсоор ирсэн. Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн шинэ байрны газар шорооны ажил, Нийгмийн даатгалын авто зогсоолын газрыг бүрэн тэгшлэх, Төмөр замын Гал унтраах газрын авто зогсоолын өргөтгөлын газар шорооны ажил, аймгийн Наадмын талбайн гадна тал болон шагай харвааны талбайн газар шорооны ажил, Аяганы хонхорт их хэмжээний айл өрхийн хог болон тээврийн хэрэгслийн хуримтлагдсан хогийг бүрэн цэвэрлэсэн. |

| | | | |
|---|---|---|---|
| 2 | Нийт ажилчдад холбогдох хууль тогтоомжийн дагуу сургалт зохион байгуулах | 200000 | Албан хаагч, ковшны оператор болон харуул хамгаалалтын ажилчдын дунд ХАБЭА-ын гарын авлага, сургалт зааварчилгааг тогтмол өгч эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамруулж ажиллаж байна. |
| 3 | Галын болон байгалийн гамшиг гэнэтийн аюул ослын үед бэлэн байх түргэн шуурхай арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлэх | 150000 | Аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 37 дугаар ангийн бүрэлдэхүүн, Сүмбэр сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах "Хос хөлөг" ХХК-ний ачилт буулгалтын талбай дээрх овоолготой болон задгай /полувагон/-д ачсан нүүрсэнд гарсан гал түймрийг унтраах тактикийн дадлага, сургалтад хамрагдсан. Мөн Онцгой байдлын газрын сургалтын танхимд Агаарын температурын өөрчлөлт, чийгшил зэргийг хэрхэн тооцох, ямар тохиолдолд уугилт үүсч байгаа талаар зөвлөмж сургалтанд нийт алба хаагчдыг хамруулсан. |
| **ДҮН** | | | |

## 7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

| Д/д | БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Хугацаа | Нийт зардал | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2022 оны БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг Аймгийн Байгаль орчны газарт хүргүүлнэ. | 3 хувь хэвлэж хүргүүлэх | БОМТ-ний биелэлтийн үр дүнг тодорхой тусгаж, фото зургаар баримтжуулсан байх | 2022 оны 11 сард | БОМТайланг танилцуулж батлах | 2022 оны БОМТ-ний хэрэгжилтийн тайланг аймгийн БОАЖГ-т хүргүүлсэн. |
| 2 | Иргэд, ажилчдаас гарсан гомдол саналыг хүлээн авч шийдвэрлэх, хяналт шинжилгээний үр дүнгүүдийг аймгийн БОГ, Сүмбэр сумын 1-р багийн оршин суугчдад танилцуулах | Хурал уулзалт зохион байгуулах | Төслийн хэрэгжилтийн үр дүн, байгаль хамгаалах чиглэлээр хийж гүйцэтгэж буй ажил, түүний үр дүн | 2022 оны 11 сард | - | Одоогийн байдлаар иргэд, оршин суугчдаас манай компанитай холбоотой санал гомдол ирээгүй бөгөөд 2022 оны БОМТ-ний хэрэгжилтийн тайланг Сүмбэр сумын 1-р багт хүргүүлсэн. |

**2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн нэгдсэн төсөв**

| № | Төлөвлөгдсөн ажил | Зарцуулсан зардал |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 800000 |
| 3 | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө | 1200000 |
| 4 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 1000000 |
| 5 | Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 1850000 |
| 6 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 800000 |
| **НЭГДСЭН НИЙТ ДҮН** | | **5650000** |

Тайлангийн зурагнууд



Цооног



Доторлоготой ариун цэврийн байгууламж



Мод тарилт



Мод тарилт



Мод тарилт



Мод усалгаа



Гадна талбай



Машины зогсоол



Сургалт, дадлага



Сургалт, дадлага



Хог түр хадгалах цэг



Аюултай хог хаягдлын хадгалалт



Агаарын шинжилгээ



Хөрсний шинжилгээ



Сургалт



Сургалт




Аяганы хонхорын хог цэвэрлэгээний ажилд оролцсон байдал

**"БАС ГОВЬ ГРУПП" ХХК**

Дархан уул аймаг, Дархан сум,
11-р баг, 6-р хороолол, 13-29 тоот

Утас: 99080470, 99072388

2022.11.22 № 51

танай___________-ны №___________-т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ ТАНАА

Мэргэжилтэн Н.Наранжаргал Төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх ажлыг д/байгуулах
2022/XI/23

Тайлан хүргүүлэх тухай

Манай компаний Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р багийн нутагт орших "Ачилт буулгалт, ложистик төв" төслийн 2022 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тооцож хүргүүллээ.

Хүлээн авч хянаж өгнө үү.

Хүндэтгэсэн

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.ОТГОНБАЯР

БАС ГОВЬ ГРУПП ХХК